

2015 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2015 оны 12 дугаар сарын 20

Улаанбаатар хот

д/д	Зорилго	Зорилтууд	Зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Гүйцэтгэл
1	2	3	4	5	6
1	Түргэн Тусламжийн үйлчилгээний хүлээгдлийг бууруулах, чанар хүртээмж, чадавхыг сайжруулах	1.1 Түргэн тусламжийн үйл ажиллагааны журмыг боловсруулах	1.1.1 Монгол улсын засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 318 тоот тогтоол “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Төлөвлөгөө хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо	4 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ төлөвлөн ажиллаж хагас жил, жилээр дүгнэсэн. Дуудлагын хүлээгдлийг бууруулах, ажилтан ажиллагсдын ур чадварыг нэмэгдүүлэх олон талт ажил зохиосноор яаралтай дуудлагын 20 минутын очилт 2,6%-иар нэмэгдсэн. Яаралтай тусламжийн сургалт 30 орчим хувиар нэмэгдэж өнгөрсөн оноос иргэдэд чиглэсэн сургалт 23 хувиар нэмэгдсэн.
			1.1.2 Эрүүл аюулгүй байдлын жилийн төлөвлөгөө гаргах	Төлөвлөгөөний биелэлтийн хувь, хамрагдалт	18 зүйлтэй төлөвлөгөө гаргаж улирал, хагас жилээр дүгнэн ажилласан.
			1.1.3 Түргэн тусламжийн үйл ажиллагааны журмыг боловсруулж, батлуулах	Тушаал	2015 оны 02 сарын 02-ны А/05 тоот тушаалаар эмнэлэг үйлчилгээний 21 журам хавсралтаар баталж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

			1.1.4 Үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлэх	Журмын хэрэгжилтийн хувь	Төв, салбаруудын хэмжээнд гарын авлага болгон 206 ширхгийг хэвлэн үйл ажиллагаандаа 100% бүрэн нэвтрүүлсэн.									
			1.1.5 Парк ашиглалтын коэфцентийг буруулж техникийн бэлэн байдлын коэфцентийг нэмэгдүүлнэ.	Автомашин хангалтын тоо, хувь	<p>Авто бааз нь 75 автомашин хөдлөх бүрэлдэхүүнтэйгээр эмнэлэг үйлчилгээнд үйлчилж байна. Өдөрт 46 автомашин үйлчилгээнд ажиллаж, парк ашиглалтын коэффициент 56 хувь, техникийн бэлэн байдлын коэффициент 94 хувьтай байна.</p> <p>(Монгол улсын дундаж үзүүлэлт ПАК- 67%-80%, ТББК- 80-95%)</p> <table border="1"> <caption>Парк ашиглалтын коэфцентийн үзүүлэлт</caption> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2014</th> <th>2015</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>ПАК</td> <td>52%</td> <td>56%</td> </tr> <tr> <td>ТББК</td> <td>48%</td> <td>94%</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлт	2014	2015	ПАК	52%	56%	ТББК	48%	94%
Үзүүлэлт	2014	2015												
ПАК	52%	56%												
ТББК	48%	94%												
			1.1.6 Дуудлагын программыг сайжруулах	Программын хувь, ашиглалт	Түргэн тусламжийн төвийн дуудлагын EIN /Emergency Information Network/ программын бүтэц, ажиллагааг сайжруулснаар дуудлагын мэдээлэл болон статистик үзүүлэлтийн программ ашиглалт 90%-тай болсон .									
			1.1.7 Ижил төст бусад орны төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	Гэрээ, хөтөлбөр, үр дүн	Нийслэлийн түргэн тусламжийн төв нь нийт 66 байгууллагуудтай хамтран ажилласан байна. Үүнд: Олон улсын байгууллага- 4, төрийн -29, төрийн бус 18, бүрэн дунд сургууль -6, цэцэрлэг - 2, хэвлэл мэдээллийн байгууллага -7 болно.									

		1.2 Нийслэлийн иргэдэд түргэн тусламжийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх	1.2.1 Чингэлтэй салбар төвийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх.	Концессийн гэрээний биелэлтийн хувь	<p>-Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендер зарлан барилгын гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулж барилгын ажлын зураг хийгдсэн.</p> <p>-Барилгын газарт орсон хувийн 4 гаражийн нөхөн олговрын төлбөрийн санхүүжилтийн асуудлыг Сүхбаатар дүүргийн газрын албанаас шийдвэрлэж өгөөгүй 2016 оны төсөвт тусгасан тул барилгын газар чөлөөлөгдөөгүйн улмаас барилгын ажил эхлээгүй хойшлогдсон.</p>
			1.2.2 Хан-Уул салбар төвийн үйл ажиллагааг эхлүүлж тогтмолжуулах	Үйл ажиллагааны үр дүн	<p>Нийслэлийн Засаг даргатай хийсэн концессын гэрээгээр 2,6 тэрбум төгрөгийн өртөгтэйгөөр баригдаж, 28 654 200 төгрөгийн тавилга эд хогшил, эмнэлгийн тоног төхөөрөмж авч тохижуулан үйл ажиллагаа явуулж байна. Нийслэлийн түргэн тусламжийн үйлчилгээний бүтэц, зохион байгуулалтыг шинэчилснээр түргэн тусламжийн үйлчилгээг дүүрэг бүрд байгуулах зорилтын хүрээнд Хан-уул салбарын үйл ажиллагаа 2-р улиралд ашиглалтад орсноор тус дүүргийн дуудлагын хүлээгдэл буурах болсон. Нийслэлийн Засаг даргатай Түргэн тусламжийн салбар барих “Төслийн зураг төсөл боловсруулах барих шилжүүлэх онцгой эрх /концесс/-ээр хийсэн гэрээний дагуу Хан-Уулын салбар 2015 оны 06 сараас өдөр тутам 8 их эмч, 3 сувилагч ээлжийн зохицуулагчтайгаар үйл ажиллагаагаа эхлүүлэн өдөрт 110-130 дуудлагад үйлчилж хүлээгдэл Хан-уул дүүргийн насанд хүрэгчдийн дуудлагын хүлээгдэл 7,4 хувиар буурч, яаралтай дуудлагын 20 минутын очилт 3.2 хувиар нэмэгдэж байгаа нь газар дээр нь үзүүлэх түргэн тусламжийн хүртээмж, чанар нэмэгдэж байна. Улмаар 2016</p>

				онд тус дүүргийн хүүхдийн дуудлагад үйлчилснээр түргэн тусламжийн цогц үйлчилгээ бүрдэх болно.	
		1.3 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах	1.3.1 Чанарын удирдлага, хяналтын тогтолцоог салбаруудын түвшинд бэхжүүлэх	Төлөвлөгөө, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо	Чанарын алба нь Хан-Уул, Сонгино хайрхан, Баян зүрх, Төв, авто бааз зэрэг салбар төвүүдэд нийт 13 чанарын багуудыг зохион байгуулж, ажиллаж байна. Чанарын багууд нь дотоод хяналтын хуваарийн дагуу нийт 156 удаагийн дотоод хяналтыг хийж, алдаа зөрчлийг бууруулж, сайн туршлагыг салбар төвүүдэд түгээн дэлгэрүүлсэн.
			1.3.2 Чанарыг сайжруулах, эрсдлийг үнэлэх олон талт ажил зохион байгуулах	Эрсдлийн үнэлгээний хувь, хамрагдалт	2015 оны 05 дугаар сарын 22, 2015 оны 06 дугаар сарын 03 ний өдрүүдэд хуваарийн дагуу Баян зүрх, Сонгино хайрхан, Хан уул, Төв салбаруудад эмнэлэг үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагаанд шалгалт үнэлгээ хийж, газар дээр нь илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар зөвлөгөө, хугацаат үүрэг даалгавар өгч биелэлтийг эргэн шалгасан. 2015 оны 09 дүгээр сарын 05- аас 10 дугаар сарын 20-ний хооронд “Газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах болон эмийн зохистой хэрэглээнд хяналт тавих” 45 хоногийн аян зохион байгуулсан. Тоног төхөөрөмжийн ашиглалтын дэвтэр хөтлөлт 50%, мөн бүгд цэвэрлэгээний хувинтай, хүчилтөрөгчийн баллон болон цэнэглэлт сайн, гуурсны нөөц сайн байв. 2015 оны I, II улиралд автомашинд суурилагдсан тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, цэнэглэлт, ашиглалт, халдвар хамгаалалт, хүчилтөрөгчийн хэрэглээ ашиглалтын талаар 7 хоногт 1-2 удаа халдвар хяналт, хөдөлмөр

				<p>хамгааллын талаар хяналт шалгалтыг тогтмол хийсний үр дүнд тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалт сайжирсан. Эмнэлгийн халдвар хяналтаар 12 төлөвлөгдсөн. 8 журмын дагуу шалгуур үзүүлэлтийг шинэчлэн гаргаж үйл ажиллагааг хянаж ажилласан. Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын А/217 тоот тушаалын хэрэгжилтийн дагуу “Хүүхдийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам”-аар Сонгино хайрхан, Баян зүрх салбаруудад 10 дугаар сараас өөрсдөө ирсэн хүүхдийг эрэмбэлэн ангилж, тэмдэглэл хөтөлсний үр дүнд өөрсдөө ирж үзүүлэх хүүхдийн тоо 95%-иар буурсан эерэг үзүүлэлт гарсан.</p> <p>Дуудлагын хүлээгдэл саатлыг бууруулахын тулд 2015 оны 11 дүгээр сард ажил амралтын үеийн дуудлагын хүлээгдэлд үнэлгээ хийж үр дүнг тооцсон.</p>
		1.3.3 Сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах ажил зохион байгуулна.	Хэрэгжүүлэх ажлын тоо, чанар	<p>2015 онд сувилахуйн тусламж үйлчилгээний чанар сайжруулах чиглэлээр удирдамж 5, журам болон гардан үйлдлийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт 10-ийг шинээр боловсруулан ажилласан. Сувилахуйн тусламж үйлчилгээний гарын авлага 20-ийг шинээр боловсруулсан. Мэргэжлийн сэдвээр зохион байгуулагдсан 0.5-2 багц цагийн нийт 7 сургалтад давхардсан тоогоор 84 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан. Эмнэлгийн ажилтны ур чадварыг үнэлэх үзүүлэх сургалтыг чанарын албатай хамтран зохион байгуулсан. Үзүүлэх сургалтад 3 ээлжийн нийт 37 сувилагч хамрагдсан. Сувилагч шинэчлэгч хүч, үр дүнтэй, үр ашигтай тусламж” эрдмийн чуулганыг зохион байгуулсан.</p>

				<p>“Нийслэлийн түргэн тусламжийн төв, Сонгино хайрхан салбарын эмч, сувилагч, жолооч нарын ажлын байрны эрсдлийн үнэлгээ” “Хүүхдийн дуудлага хүлээн авагч эмч, сувилагч нарын ажлын байран дахь сэтгэл зүйд хийсэн судалгаа” “Эмч эмнэлгийн ажилчдад өгсөн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа” илтгэлүүд эхний 3 байр эзэлсэн. Шалгарсан илтгэлүүдийг Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эмнэлгүүдийн нэгдсэн эрдмийн чуулганд явуулсан ба нийслэлийн эрүүл мэндийн газраас эрхлэн гаргасан “Сувилагч шинэчлэгч хүч, үр дүнтэй, үр ашигтай тусламж” эрдмийн чуулганы хураангуй номонд хэвлэгдсэн.</p> <p>“Сувилагч мэргэжил миний бахархал” нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Нийт 148 үйлчлүүлэгчид сувилахуйн тусламж үзүүлж 150 ш гарын авлага боловсруулан эцэг эх, үйлчлүүлэгч нарт эрүүл мэндийн боловсрол олгосон. Үнэлгээнд 7 эмийн санч 29 сувилагч хамрагдсан. Үнэлгээг хийснээр сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нар харилцан бие биедээ стандарт мөрдөлтөөр хяналт тавьсан, гарсан алдааг газар дээр нь арилгуулсан тустай ажил болсон.</p> <p>Сувилахуйн албанаас түгээмэл үйлдлийн стандартын хэрэгжилтийн шалгалт үнэлгээ 12 удаа, мэргэжлийн үнэлгээ 4 удаа, дотоод хяналт 17 удаа хийсэн.</p> <p>Дунд хугацаанд 40 сайн туршлага нэвтрүүлсэн байсан бөгөөд 2015 онд 13 сайн туршлага нэвтрүүлсэн буюу 32.5% нэмэгдсэн байна.</p>
--	--	--	--	--

		1.3.4 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн сургалт зохион байгуулах	Үнэлгээний хувь болон хамрагдалт	Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу захирлын 2015 оны 12 сарын 10 ны өдрийн А/51 тоот тушаалаар шинэчилсэн.Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 6 сараар хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгслийг шинэчлэн үечилсэн сургалтуудыг явуулсан.
		1.3.5 Эмч, ажилчдыг амилуулах сургалтад хамруулж, үр дүн тооцох	Хөтөлбөр сургалтад хамрагдсан ажилтны тоо, хувь	2015 оны 02 сарын 14 өдрөөс эхлэн Амилуулах суурь тусламжийн сургалтыг 7 удаагийн нийт 452 цаг, өмнө нь хамрагдаж байсан эмч, сувилагч болон шинээр ажилд орж буй бүх мэргэжилтэн хамрагдаж нийт давхардсан тоогоор 317 эмч, сувилагч хамрагдсан. Нийт эмч болон сувилагч нарын сургалтын өмнөх шалгалтын дундаж 62,5% байсан, сургалтын дараах байдлаар 75,4%- тай болж 12,9% өссөн. Дээрх сургалт явагдсанаар эмч болон сувилагчдын багаар ажиллах чадвар сайжирч дуудлагадаа түргэн шуурхай ажиллах боломж нэмэгдсэн.
		1.3.6 Сэтгэл ханамжийн судалгааг шинэлэг хэлбэрээр авч үр дүнг тооцох	Судалгааны нэр төрөл дүгнэлтийн дагуу хийсэн ажил	2014 онд Эрүүл Мэндийн Сайдын 2014 оны 01 сарын 13-ны өдрийн Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай 13 тоот тушаалын дагуу 202 эмч, эмнэлгийн ажилтнууд, Баян зүрх, Сонгино хайрхан дүүргийн салбараар үйлчлүүлсэн 449 хэрэглэгчдийг хамруулан улирал бүр сэтгэл ханамжийн судалгаа авч, статистик боловсруулалтыг excel программыг ашиглан хийв. Нийт 651 хэрэглэгч хамрагдсан ба эмнэлгийн ажиллагсдын 55,6% нь судалгаанд хамрагдлаа. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны дүн 1. Баянзүрх, Сонгино хайрхан дүүргийн салбараар үйлчлүүлсэн 449 үйлчлүүлэгчдээс байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний

					<p>чанар, аюулгүй байдал, тэгш байдал, ашиг сонирхол гэсэн 5 бүлэг 29 асуултаар судалгаа авсан.</p> <p>2. Судалгаанд оролцогчдын 40% нь манай байгууллагаар 2 түүнээс дээш удаа үйлчлүүлсэн байна.</p> <p>3. Судалгаанд оролцогчдын 96,3% нь байгууллагын соёлд эерэг</p> <p>4. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд 97,8% нь эерэг</p> <p>5. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд 97.4% нь эерэг</p> <p>6. Удирдлага, зохион байгуулалтад 92,7% нь эерэг сэтгэл ханамжтай байна.</p> <p>7. Ерөнхий сэтгэл ханамж 85,0% байна.</p>
		1.4 Түргэн тусламжид хэрэглэгдэх эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ.	1.4.1 Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, эмч ажилчдад эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх	Эмийн тарианы зарцуулалтын хувь	<p>-2015 онд нийт дуудлагын 120 эмчид “Эмийн зохистой хэргэлээ”, “Зүрх судасны өвчлөлийн үед хэрэглэх эм”, “Жор бичилтийн стандартыг хэвшүүлцгээе”, “Өвдөлтийн менежмент” зэрэг 4 төрлийн сургалтад хамруулж эмч нарын эмийн талаар мэдээллийг нэмэгдүүлсэн.</p> <p>-Мэдрэл, дотор, зүрх судасны эмч нартай хамтран наран туул-2 худалдааны төвийн ажилчдын дунд эмийн зохистой хэрэглээ, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг нийт 70 хүнд хамруулан хийсэн.</p>
2	Анхан шатны тусламж, үйлчилгээг дээшлүүлэх	2.1 Иргэдэд чиглэсэн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажил зохион байгуулах	2.1.1 Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран иргэдэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулах	Нэвтрүүлгийн тоо хувь	<p>Телевизийн нэвтрүүлэг 48, радио нэвтрүүлэг 1, хэвлэлийн мэдээлэл 3 нийтэлсэн.</p> <p>- Оллоо, MNTV-ийн 120/80 нэвтрүүлэг, “Монгол телевиз -2”, HD Монгол,”Сүлд “зэрэг телевизээр “Амилуулах суурь тусламж буюу гэмтлийн суурь тусламж, хордлого болон гадны шалтгаант гэмтлүүд” зэрэг сэдвээр иргэдэд зориулсан шууд</p>

					<p>нэвтрүүлэгт 6 удаа, “Эх орон” тамхины хар хөнөөл, дам тамхидалт сэдвээр, TV 5 телевизийн “Эрүүл амьдарцгаая” эрүүл мэндийн 42 удаагийн ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх нэвтрүүлэг бэлтгэгдсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> - Монголын үндэсний радиогийн хүүхдийн нэвтрүүлэгт “Анхан тусламжийг найздаа болон нөхөртөө хэрхэн зөв үзүүлэх бэ” сургалт зөвлөгөө хийсэн. - ”Чөлөөт сэтгүүлчдийн холбоо”, “Монголчууд “сэтгүүлтэй хамтран эрдэм шинжилгээний материал хэвлүүлсэн ба Дани Монголын нийгэмлэгтэй хамтран ном бэлтгэн гаргахад оролцсон.
			2.1.2 Иргэдийн эрүүл мэндийн боловсрол, эрүүл аж төрөх зан үйлийг өөрчлөхөд чиглэгдсэн олон талт арга хэмжээ зохион байгуулах.	Зохион байгуулсан ажлын тоо	<p>Төрийн -29, төрийн бус 18, бүрэн дунд сургууль -6, цэцэрлэг -2, хэвлэл мэдээллийн байгууллага -7 байгууллагатай хамтран эрүүл мэндийн боловсрол оглох сургалт 36, нээлттэй хаалганы өдөрлөг 1, урьдчилан сэргийлэх үзлэг 1, радио нэвтрүүлэг 1, хэвлэлийн мэдээлэл 3, телевизийн 48 удаагийн эрүүл мэндийн боловсрол олгох нэвтрүүлэг бэлтгэн хүргэсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Оюутан сурагчдад БЗХӨ-с сэргийлэх, бэлгийн амьдралын зөв дадалд хэвшүүлэх зорилгоор “Наран”, “Зууны билэг”, “Оюуны оньс”, “Оюуны нахиа”, “Глобал удирдагч” бүрэн дунд сургуулиудад эрүүл мэндийн сургалтыг хийсэн. - МУЗН-тэй хамтран хүүхэд залуучуудын дундах “Амьдралын зөв хандлага” сургалтуудыг хамтран зохион байгуулсан. - Сэтгэлийн хөг ТББ-тай хамтран СХД-н 6,7 хорооны иргэдэд эрүүл зөв хооллолт сэдвээр

					<p>нээлттэй хаалганы өдөрлөг зохион явуулсан.</p> <p>- Төрийн банк, Монгол банк, Шүүхийн ерөнхий шазар, Тагнуулын ерөнхий газрын ажилчид, Онцгой байдлын эмч, сувилагч, Улаанбаатар хотын дүүргийн эрүүлжүүлэх байрны эмч нарт, ДЦС2, ДЦС3, Сонгино хайрхан дүүргийн 105 цэцэрлэг, Их дээд болон ерөнхий боловсролын 14 сургууль, Тахарын алба, Нялхсын сувилалд гэх мэт газарт сургалтыг зохион байгуулж хүн амын эрүүл мэндийн боловсролд хувь нэмэр оруулсан.</p> <p>- Улаанбаатар чуулгын 51 ажилчдад 8 чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг хийн эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн.</p>
			2.1.3 Цаг үеийн болон улирлын чанартай өвчлөлийг угтуулсан ажил зохион байгуулж, сургалт мэдээллээр хангаж ажиллах	Төлөвлөгөө, зохион байгуулсан ажлын хувь	Байгууллага дээрх сургалтуудаас 25 нь цаг үетэй уялдан явагдсан болно. Халдварт өвчнөөр 8 удаа, эх нярайн тусламж 3, зүрх судасны өвчлөл 7, мэдрэлийн өвчлөл 4, осол гэмтэл, хордлого 3 удаа мэргэжлийн эмч, багш нараар сургалт явуулсан. Тус сургалтыг явуулснаар эмч нарын мэдлэг сүүлийн үеийн эмнэл зүйн удирдамж , эмчилгээ, улирлын өвчлөлөөр мэдээлэл авч, мэдлэг, ур чадвар нэмэгдсэн.
		2.2 Эмнэлгээс шалтгаалах халдварын шинэ технологи нэвтрүүлэх	2.2.1 Халдвар хамгааллын тушаал зөвлөмжийн дагуу ажиллах	Зохион байгуулсан ажлын тоо	<p>Эмнэлгийн халдвар хяналтаар 12 зүйл төлөвлөгдсөн. Үүний үйл ажиллагааны 10 төлөвлөгөө биелэгдсэн.</p> <p>8 журмын дагуу шалгуур үзүүлэлтийг шинэчлэн гаргаж сар болгон шалгуур үзүүлэлтээр шалгаж хянаж ажилсан. Үүний үр дүнд их эрсдэлтэй гэж дүгнэгдэж байсан салбарууд бага эрсдэлтэй болж сайжирсан.</p> <p>Улаан бурхан халдварт өвчний</p>

					<p>дархлаажуулалтанд нийт 120 эмч, сувилагч нар хамрагдсан.</p> <p>Нийт 3 ээлжийн 250 эмч, сувилагч, жолооч нарыг “Томуу томуу төст” халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтанд хамруулсан. Нийт орох эмч, сувилагч жолооч нарын 68,4 хувь орсон. Үүний үр дүнд олныг хамарсан дэгдэлтээс урьдчилан сэргийлсэн. Улирлын байдалтай гарч буй халдварт өвчний дэгдэлтийн үед эмийн сангийн нөөцийг 7 хоногоор хангуулж бэлэн байдалд ажилласан.</p>
			2.2.2 Халдвар хамгааллыг сайжруулах шинэ санаа, дэвшилтэд арга барилыг нэвтрүүлж үр дүнг тооцох	Шинээр хэрэгжүүлсэн ажлын тоо	<p>2015 онд 2 үзүүлэх сургалт зохион байгуулсан.</p> <p>Чанарын албатай халдвар хяналтын алба хамтран 2015 оны 4 сарын 2- 24 хүртэл “ тусламж үйлчилгээ чанар сайжруулъя” сэдэвтэй үзүүлэх сургалтыг нийт 3 ээлжийн 153 эмч, 37 сувилагч, 114 жолооч нарын дунд зохион байгуулсан. Сувилахуйн албатай халдвар хяналтын алба хамтран 2015 оны 09 сарын 09 өдөр “Халдварын сэргийлэлтийн чанарыг сайжруулъя” сэдэвт үзүүлэх сургалтыг 142 эмч, 34 сувилагч, 114 жолооч нарын дунд зохион байгуулснаар халдвар хамгаалал, эмнэлгийн хог хаягдлын ялган ангилалт мөн халдваргүйтгэл цэвэрлэгээг, багаж тоног төхөөрөмжийн ариутгалыг тогтмол хийснээр эмнэлгийн дотоод халдвараас урьдчилан сэргийлсэн.</p>


3	Хүний нөөцийг хөгжүүлж, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх	3.1.Ажилтан, ажиллагсдын мэдлэг мэргэшлийг үе шаттайгаар дээшлүүлнэ.	3.1.1 Хүний нөөцийн судалгааг гарган эмч, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтад хамруулж, оновчтой байршуулах	Судалгааны төрөл, мэргэшсэн эмч, ажилчдын тоо, хувь	2015-2017 оны нийт эмч, эмнэлгийн дунд мэргэжилтний судалгааг гаргаж төрийн зардлаар 3 эмч, хувийн зардлаар 10 эмчийн нарийн мэргэжлийн сургалтад 2 эмчийг зүрх судасны чиглэлээр сургалтад хамруулсан. Хүүхдийн өвчний цогц менежмент 80 цагийн сургалтад 60 эмчийг хамруулсан 4 салбарт мэргэшлээр хувиарлаж ажилласан.						
			3.1.2 Эмч ажилчдыг гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалтад шаттайгаар хамруулах үе	сургалтад хамрагдсан ажилтны тоо	<p>Удирдлагын академитай хамтран Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 40 эмч ажилчдад 25 өдрийн 37,5 цагийн англи хэлний анхан болон дээд шатны сургалт явуулсан. Сургалтын өмнө эмч ажилчдаас ангил хэлний түвшин тогтоох шалгалт авахад 43% мэдлэгтэй байсан бол сургалтын дараа 79,3% болж, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах хамтын ажиллагаанд оролцох, манай оронд зохиогдох гадаадын дээд хэмжээний уулзалт болон арга хэмжээнүүдэд ажиллах эмч ажилчдын гадаад хэлний түвшин 36,3%-аар дээшиллээ.</p> <div data-bbox="1447 935 2119 1176"> <p style="text-align: center;">ҮР ДҮН</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <thead> <tr> <th>Төлөв</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>өмнө нь</td> <td>43%</td> </tr> <tr> <td>дараа нь</td> <td>79.30%</td> </tr> </tbody> </table> </div>	Төлөв	Хувь	өмнө нь	43%	дараа нь	79.30%
Төлөв	Хувь										
өмнө нь	43%										
дараа нь	79.30%										

3.1.3 Эмч ажилчдын ажлын байрны сургалтыг тогтмолжуулж чанаржуулах

Сургалтын төлөвлөгөө, хамрагдсан ажилчдын тоо


Байгууллагын эмч, ажилчдыг чадавхжуулах нийт 44 удаагийн сургалт явуулсан. Үүнд: лхагва гариг бүр нийт 30 удаа 30 цагийн сургалт, хүүхдийн тусламж үйлчилгээ 4 удаа 320 цаг, Зүрхний цахилгаан бичлэг зөв уншиж оношлох 2 удаа 60 цаг, жор бичилтийн стандартыг хэвшүүлэх 1 удаа 5 цаг, амилуулах суурь тусламжийн 7 удаагийн 452 цагийн сургалтуудыг явуулснаар эмч нарын мэдлэг сүүлийн үеийн эмнэл зүйн удирдамж, эмийн мэдээлэл, улирлын өвчлөлөөр мэдээлэл авч, мэдлэг, ур чадвар нэмэгдсэн. Байгууллага дээрх сургалтууд цаг үетэй уялдан явагдсан болно.

- Лхагва гариг бүр халдварт өвчнөөр 8 удаа, эх нярайн тусламж 3, зүрх судасны өвчлөл 7, мэдрэлийн өвчлөл 4, осол гэмтэл, хордлого 3, эм зүй 2, ёс зүй харьцаа хандлага 2, онош зүй 1 удаа тус тус мэргэжлийн эмч, багш нараар сургалт явуулсан.



Тус сургалтад эмч, сувилагч нар 97,7% ирцтэй хамрагдаж, сургалтыг явуулснаар эмч нарын мэдлэг дээшилж, газар дээрх болон эмнэлэг


хүртэлх тусламж сайжирч байна.



- Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “Хүүхдийн тусламж үйлчилгээ” сэдэвт 320 цагийн сургалтад 50 эмч хамрагдсан. Сургалтаар нярайн үзлэг, нярайн шарлалт, ялган оношилгоо, ХӨЦМ-ээр хүүхдийг үнэлэх, зөвлөгөө өгөх, эмчлэх аргад суралцсан. Эмч нарыг тус сургалтад хамруулснаар хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ үзүүлэх мэдлэг чадвар дээшилж улмаар дүүргүүдийн хүүхдийн түргэн тусламжийн үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдэж байна.

- 2016 онд Монгол улсад зохиогдох АSEM-ийн дээд хэмжээний уулзалтын хүрээнд зүрхний цахилгаан бичлэгийн нийт 25 өдөр, 60 цаг, 39 эмч 78,7%-тай тасралтгүй сурч дүүргэлээ. Тус төвийн эмч нар зүрхний цахилгаан бичлэг уншиж сурснаар мэдлэг мэргэжил дээшилж, эмнэлгийн тусламж үйлчилгээг газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламжийг стандартын дагуу эмчилгээг цаг алдалгүй хийж, эмнэлэг рүү тээвэрлэх ба оношилгооны ач холбогдолтой болж тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, тус сургалтаар цаашид зүрх судасны тусламж үйлчилгээ үзүүлэх эмч нарын тоо 39-өөр нэмэгдэж байна.

- Жор бичилтийн стандартаар 5 цагийн 108 эмчид сургалт явуулж, сургалтын өмнөх байдал 9,2% хангалттай, сургалтын дараа 78,9% хангалттай үнэлгээтэй болж 69,7%-аар өссөн. Сургалтыг явуулснаар хүүхдэд зонхилон хэрэглэгдэх эмийн тунг тооцож, жорыг стандартын дагуу бичиж, эмийн жорыг стандартын дагуу бичсэнээр үйлчлүүлэгчдэд учирч болох эрсдэл буурч, эмийн зохистой хэрэглээ сайжирсан.



- Амилуулах суурь тусламжийн сургалтад 7 удаагийн нийт 452 цагийн сургалтад нийт давхардсан тоогоор 317 эмч, сувилагч хамрагдсан. Нийт эмч болон сувилагч нарын сургалтын өмнөх шалгалтын дундаж 62,5% байсан, сургалтын дараах байдлаар 75,4%- тай болж 12,9%- аар өссөн. Дээрх сургалт явагдсанаар эмч болон сувилагчдын багаар ажиллах чадвар сайжирч, чадварлаг баг түргэн шуурхай ажиллах боломж нэмэгдсэн. Амилуулах суурь тусламжийн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын өрөөг ажлын өдрүүдэд нээлттэй байлган ээлжээс буусан ажилтнууд ур чадвараа сайжруулж байна.

			<p>3.1.4 Түргэн тусламжын мэргэшсэн жолооч бэлтгэх хөтөлбөр гаргаж зохих шатны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх</p>	<p>Мэргэшсэн жолооч бэлтгэх хөтөлбөр боловсруулж батлуулсан байх</p>	<p>Мэргэшсэн жолоочийн сургалтад нийт 120 жолоочийг “Түргэн тусламжийн төвийн мэргэшсэн жолооч” тусгай сертификат, үнэмлэх олгосон. Энэ сургалтаар анхан шатны тусламжийг хэрхэн зөв үзүүлэх, автомашины ариутгалын хоёр хувингийн арга, автомашины эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, замын хөдөлгөөний дүрэм, журам, хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг эзэмшин төгссөн. Ингэснээр түргэн тусламжийн жолооч нь автомашин барихаас гадна эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадвартай техникийн ажилтан болно.</p>										
			<p>3.1.5 Гадаадын ижил төст төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах</p>	<p>Зохион байгуулсан сургалтын, ажилчдын тоо</p>	<p>Гадаадын 5 байгууллага болох ХБНГУ-ын Эссэн хотын эмнэлэг, гал унтраах төвтэй хамтран 5 удаа сургалт, 1 туршлага солилцох, нийт 6 удаа, “АМДА” олон улсын байгууллагатай сургалт 1 удаа, JICA олон улсын байгууллагатай зөвлөгөөн 1 удаа, НҮБ Африкийн холбоотой хамтран энхийг сахиулахаар 1 удаа, БНСУ-д туршлага солилцох сургалт 1 удаа хамтран зохион байгуулсан.</p> <div data-bbox="1451 962 2134 1201" data-label="Figure"> <p style="text-align: center;">хамтарсан сургалт</p> <table border="1"> <thead> <tr> <th>Организаци</th> <th>Хамтарсан сургалт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>ХБНГУ</td> <td>5</td> </tr> <tr> <td>АМДА</td> <td>1</td> </tr> <tr> <td>JICA</td> <td>1</td> </tr> <tr> <td>БНСУ</td> <td>1</td> </tr> </tbody> </table> </div> <p>- Монгол Германы хамтарсан “Яаралтай тусламж, эмнэлгийн эрүүл ахуйг сайжруулах” хамтын ажиллагааны хүрээнд байгууллагын 126 жолоочид 5 удаагийн сургалт хийж, 87,6% хангалттай үнэлэгдсэн. Үүнээс 10 жолооч эмнэлгийн туслах ажилтнаар бэлгэдэж байгаа. 28</p>	Организаци	Хамтарсан сургалт	ХБНГУ	5	АМДА	1	JICA	1	БНСУ	1
Организаци	Хамтарсан сургалт														
ХБНГУ	5														
АМДА	1														
JICA	1														
БНСУ	1														

					<p>сувилагчид 1 удаагийн сургалт зохион явуулсан. Тус сургалтаар ариутгалын алкосол ашиглан 2 хувингийн аргаар байгууллагын доторх болон автомашиныг цэвэрлэж, халдваргүйтгэснээр түргэн тусламжийн авто машин цэвэр, халдвар дамжих эрсдлийг бууруулсан. “Халдварын сэргийлэлт, хяналт” гуравдугаар зөвлөгөөнийг Эрүүл мэнд спортын яам, Нийслэлийн түргэн тусламжийн төв нар амжилттай зохион байгуулсан. Сургалтад нийслэл болон хөдөө орон нутгийн харьяа байгууллагуудын тархвар судлаач, эмч эмнэлгийн 102 ажилчид хамрагдаж, Герман улсын туршлагаас суралцаж, өөрийн байгууллагад нэвтрүүлэх боломжтой болсон.</p> <p>- “АМДА” олон улсын байгууллага болон Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дэмжлэгээр Япон улсын яаралтай тусламжийн доктор ноён Нагаминэ Нийслэлийн түргэн тусламжийн 110 эмч, сувилагч болон Нийслэлийн харьяа газруудын 68 эмч нарт “Орчин үеийн яаралтай тусламжийн чиг хандлага болон зонхилон тохиолдох өвчнүүдийн яаралтай үзүүлэх тусламж” сэдвээр сургалт хийж, эмч мэргэжилтний ур чадварт үнэлэлт өгснөөр яаралтай тусламжийн мэдлэг ур чадвар дээшлэн, олон улсын түвшинд ойртсон. Нийслэлийн түргэн тусламжийн төвийн эмч, сувилагч болон нийслэлийн харьяа эрүүл мэндийн газрын эмч, сувилагч нарын яаралтай тусламжийн мэдлэг, дадлага эзэмшүүлэх орчин үеийн эмчилгээний чиг хандлагын стандарттай танилцсан.</p> <p>- JICA олон улсын байгууллагын төлөөлөгчид “Joint conference of emergency medicine in</p>
--	--	--	--	--	---

					<p>Mongolia and Japan” зөвлөгөөний хүрээнд Монгол болон Японы яаралтай тусламжийн тогтолцоо, төгсөлтийн дараах яаралтай тусламжийн сургалтад Япон улсын туршлагыг нэвтрүүлэхэд хөтөлбөр боловсруулж, 2 орны газар дээрх болон эмнэлэг хүртэлх эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах талаар хэлэлцсэн.</p> <p>- Солонгос улсын Сөүл хотын Orthoped plastik hospital-д сургалтын менежер Д.Бат-Ундрах, эмч Б.Эрдэнэболор нар “Үе шилжүүлэн суулгах мэс заслын” чиглэлээр 1 жилийн олгох курс амжилттай төгсөж ирсэн.</p> <p>- Бүгд найрамдах Судан Улсын Дарфур муж дахь Африкийн холбоо, НҮБ-ын хамтарсан энхийг сахиулах ажиллагаанд 1 жилийн хугацаатай 2 эмч амжилттай үүрэг гүйцэтгэж ирсэн.</p>
		3.2 Байгууллагын түвшинд ёс зүйн харьцаа хандлагын хэм хэмжээ болон ил тод байдлыг сайжруулах	3.2.1 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харьцаа хандлагыг дээшлүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах	Төлөвлөгөө биелэлтийн хувь	<p>Ёс зүйн хэсгийн хороон 14 заалт бүхий төлөвлөгөө гаргаж 93.7 хувийн биелэлттэй ажилласан. Харьцаа хандлага ёс зүй, сайдын тушаалаар 5 удаагийн 6 цагийн сургалт зохион байгуулж нийт давхардсан тоогоор их эмч 548, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 146, бусад ажилтан албан хаагчид 184 хамрагдсан. Инээмсэглэл аян зохион байгуулснаар харьцаа хандлагатай холбоотой гомдол гараагүй.</p>
			3.2.2 Нийт ажилчдын ажил дүгнэх үзүүлэлтийг шинэчлэн цалин хөлс урамшууллын оновчтой хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх	Ажил дүгнэх үзүүлэлтийг шинэчлэсэн тушаал	<p>2015 оны 02 сарын 02-ны А/05 тоот тушаалаар ажил дүгнэх үзүүлэлтийг баталж, улирал бүр нийт 4 удаа дүгнэж нийт давхардсан тоогоор 424 ажилтныг 60,375,950 төгрөгөөр урамшуулсан.</p>

			3.2.3 Байгууллагын ил тод байдал, авилаг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	Нийслэлийн Иргэдийн Хурлын төлөөлөгчдийн 2015 оны 01 сарын 29-ны 23/01 тогтоолын дагуу 18 зүйл заалт бүхий төлөвлөгөө гаргасан. -Авлигын эсрэг Нийслэлийн хөтөлбөрөөр нийт 282 эмч, сувилагч, жолооч, захиргааны ажилтан нарт минутын танилцуулга хийсэн. Захирал Ц.Пүрэвдаш, ахлах нягтлан Б.Отгонтэнгэр нарын 2014 оны “Хөрөнгө оруулгын мэдүүлэг” 01 сарын 15 нд гаргаж Нийслэлийн эрүүл мэндийн газар болон Авлигатай тэмцэх газарт гаргаж өгсөн. Шилэн дансны 24 заалт бүхий төлөвлөгөө гаргаж батлуулж 100 хувийн биелэлттэй ажиллаж байгууллагын веб сайтад хуваарийн дагуу биелэлтээ байршуулан ажилласан. Шилэн дансны хоёр удаагийн сургалтад захирал Ц.Пүрэвдаш, ахлах нягтлан Б.Отгонтэнгэр нар хамрагдаж нярав нягтлан нийт 8 ажилтан 2 цагийн сургалт зохион байгуулсан
		3.3.Эрүүл аюулгүй орчин бүрдүүлж ажиллах	3.2.4 Харьцаа хандлагын зөрчил гомдол гарсан тохиолдолд шуурхай шийдвэрлэн хариу мэдэгдэх	Гомдлын тоо, шийдвэрлэсэн байдал,	Нийт 175 өргөдөл гомдол ирсний 128 талархал,эмнэлэг үйлчилгээний чанар хүртээмжтэй 8, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, харьцаа хандлагатай холбоотой 12, үндэслэлгүй гомдол- 27 ирснийг хуулийн хугацаанд шалгаж 8 шийдвэрлэж ажилласан.
			3.3.1 Ажлын байрны тав тухтай орчин бүрдүүлэх болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	Нийгмийн асуудал шийдвэрлэх 21 заалт бүхий төлөвлөгөөний 97.3 хувийн биелэлттэй ажилласан. Үүнд: Монгол Улсын засгийн газрын тогтоол-4 Нийслэлийн засаг даргын захирамж-2 Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын

					тушаал-30 Албан даалгавар-4
			3.3.2 Ажилчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор хяналтын системийг боловсронгуй болгох	Шинээр нэмэгдсэн хяналтын камерын тоо, камераар илрүүлсэн зөрчлийн тоо	Авто бааз болон аюулгүй байдлыг хангах зорилгоор 2015 онд авто баазын хяналтын камерын системийг бүрэн шинэчилж 16 ш камер суурилуулсан. Баян зүрх салбарт 2 ш камер нэмэлтээр суурилуулсан. -103 төвд 8 ш камер -Бааз 16 ш камер -БЗД-ийн салбар – 8 ш камер -СХД-ийн салбар - 8 ш камер -Хан-Уул салбар – 8 ш камер тус тус ажиллаж байна. Хадгалах хугацаа 1-с 2 сар.
		3.4 Ажилчид болон өндөр настны нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ	3.3.3 Салбар төвүүдэд чийрэгжүүлэх өрөө бий болгох	Чийрэгжүүлэх өрөөний тоо, тохижилт	-Хануул дүүргийн салбарт Төвдийн Од-сэр Ринбүчийн хандиваар “Иог, бясалгалын өрөө”-г тохижуулснаар ажилчдын алжаал тайлах, стрессээс ангижрах таатай орчин бүрдсэн байна. -Авто баазад, Баян зүрх дүүргийн чийрэгжүүлэх танхимыг тохижуулснаар. Байгууллагын ажилчид чийрэгжүүлэх танхимд чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэн 1.869.000 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч тохижуулж ажиллаж нийт 5658 хүнд үйлчилж байгууллагын хэмжээнд 398 кг жин хассан.
			3.4.1 Тэргүүний ажилчдыг гадаад, дотоод аялал явуулах	Аялалд явсан хүний тоо, мөнгөн дүн	Нийт 12 ажилтныг Булган, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймгуудын байгалийн үзэсгэлэнт газраар 10 хоногийн аялал зохион байгуулж 1.8 сая төгрөг зарцуулсан.

			3.4.2 Ажилчдын рашаан сувилалд хөнгөлттэй нөхцөлөөр хамруулах	Хамрагдсан ажилчдын тоо, хөнгөлөлтийн дүн	2015 онд 4 ажилтан рашаан сувиллын /654,900/ төгрөгийн хөнгөлөлт олгосон.
			3.4.3 Тэтгэвэрт гарсан ахмадуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажил зохион байгуулах	Тэтгэмж, тусламжид хамрагдсан ахмадын тоо.	Сар шинийн баяр болон олон улсын ахмадын өдөр хүлээн авч хүндэтгэл үзүүлэн 196 өндөр настанд 12.989.000 төгрөг зарцуулсан. Өндөр насны тэтгэвэрт гарсан 3 ажилтныг 3 сарын тэтгэмж, 2 ажилтныг эрүүл мэндийн хуулийн 29 зүйлийн дагуу 24 сарын тэтгэмжид хамруулсан.
4	Төсвийн өмч хөрөнгийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах	4.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалтанд арвилан хэмнэлт гаргах	4.1.1 Батлагдсан төсвийг “Төсвийн тухай хууль”, бусад санхүүгийн холбогдох хууль, эрхзүйн актын дагуу хуваарилан зарцуулах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ	2015 онд батлагдсан 6522.9 сая төгрөгийн төсөв 2015.07 сараас эхлэн 227.7 сая төгрөгөөр буурч өөрчлөлт орж 6,254.7 сая төгрөг болж батлагдсан. Батлагдсан төсвийг сар бүрийн хуваарийн дагуу зардлыг зориулалтын дагуу зарцуулж төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг цаг хугацаанд нь тайлагнасан. Өмнөх оноос дуудлагын тоо 7.6 хувиар өссөн боловч эмнэлэг үйлчилгээтэй шууд холбогдон гарах шатахууны төсөв 133.4 сая төгрөгөөр буурч санхүүгийн хувьд хүндрэл үүссэн. Гэвч хоногт гарах автомашины шатахууны олголтыг хасаж төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллаж 26.8 сая төгрөгөөр өрийг багасгаж ажилласан. Шинээр ашиглалтад орсон Хан-Уул дахь салбарын тохижилтод төсөвтөө багтаан аж ахуйн зардалдаа тулгуурлан материал авч өөрсдийн ажилчдын хүчээр тохижуулсан.

			4.1.2 Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг сайжруулахад УСНБББББ-нд өөрчлөлт оруулах,	Санхүүгийн тайлан, баланс	Сангийн яамнаас “Төрийн сангийн мөнгөн үйл ажиллагаа”-нд орсон өөрчлөлтийг тусгасан.
			4.1.3 Засаж сэлбэж болох хөрөнгийг дотоод ажлын хүч, бага өртөг, зардлаар засаж, ашиглалтад оруулах “Аж ахуйн ажлын төлөвлөгөө”-г гаргах	1-4 улирлын аж ахуйн төлөвлөгөө, биелэлтийн хувь	Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, засварлаж ашиглалтад оруулах “Аж ахуйн төлөвлөгөө”-г улирал тутамд гаргаж хийх ажлын хүрээнд 5 нэгж объектуудад төлөвлөгөөний дагуу ажилласан. Мөн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах, ээлтэй орчин бүрдүүлэх, шинэ бүтээлч ажил, санал санаачлалыг дэмжих ажлын хүрээнд гадаад ажлын тохижилтын 9 шалгуур заалт, дотоод ажлын тохижилтын 6 шалгуур заалт, үйлчилгээний соёлыг үнэлэх 5 шалгуур заалтын хүрээнд төсвийн болон ажилчдын зохион байгуулалтын дүнд бий болсон хөрөнгөөр тохижилт хийж, эвдэрсэн сандал, ширээг гарын доорх материалаар ашиглалтыг сайжруулсан.
		4.2. Бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулалттай явуулах	4.2.1 Арвилан хэмнэлт гаргах зардлыг багасгах “Худалдан авалтын төлөвлөгөө”-г гаргах	Төлөвлөгөө, биелэлтийн хувь	Өмнөх оноос эмнэлэг үйлчилгээтэй шууд холбогдон гарах шатахууны төсөв 133.4 сая төгрөгөөр буурч, дуудлагын тоо 7.6 хувиар өссөн. Иймд үүсэж болох өр төлбөрийг багасгах хэмнэлт гаргах чиглэлийг барьж хоногт 1 автомашинаас 2 литр шатахууныг хасаж нийтдээ 16264 литр буюу 26.8 сая төгрөгөөр өрийг багасгаж ажилласан.

			4.2.2 Худалдан авалтын босго үнээс давсан хөрөнгө, худалдан авалтын сонгон шалгаруулалтыг явуулах	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, гэрээний тоо	Худалдан авалтын журмыг дагаж шууд худалдан авах босго үнээс давсан хөрөнгийн зах зээлийн үнийн судалгааг явуулж “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-өөр хэлэлцүүлэн НӨХГ-т хандаж зөвшөөрлийн дагуу шийдвэрлүүлсэн.
		4.3.Төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, төлөвлөлтийн байдлыг цахим хуудсаар олон нийтэд ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, мэдээлэх, мэдээллийг иргэд, олон нийтийн оролцоог хангах хяналттай байхаар “Шилэн данс” нэвтрүүлэх	4.3.1 Төсвийн хөрөнгийн зарцуулалтыг гадна орчны хяналттай байлгах “Шилэн данс”-ны төлөвлөгөөг гарган ажиллах	Төлөвлөгөө, биелэлтийн хувь	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар Нийслэлийн засаг даргын 2015 оны 01 сарын 08-ны өдрийн А/01 тоот захирамж гарч “Шилэн дансны төлөвлөгөө”-г гарган ажиллаж байна. Цахим хуудсаар олон нийтэд ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, мэдээлэх, мэдээллийг иргэд, олон нийтийн оролцоог хангасан байхаар “Шилэн данс” шинээр нээж, Нийслэлийн засаг даргын тамгын газраас өгсөн чиглэлийн дагуу Нийслэлийн шилэн дансны сайт http://www.shilendans.ub.gov.mn -д байгууллагын онцлогт тохируулж нээсэн дараах маягтуудад мэдээллүүдээ цаг хугацаанд нь оруулж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Сар, улирлын төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулан, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт <u>хавсралт 2</u>-д заасан маягтын дагуу “Шилэн данс”-нд байршуулсан • Жилийн төсөв, гүйцэтгэлийг хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын хагас, бүтэн жилийн үзүүлэлтийг <u>хавсралт 1</u>-д заасан маягтын дагуу “Шилэн данс”-нд байршуулсан

					<ul style="list-style-type: none"> • Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг <u>хавсралт 8</u>-д заасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн • Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр <u>хавсралт 9</u>-д заасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн • Аливаа хөрөнгө мөнгөтэй холбоотой гарсан шийдвэрийг <u>хавсралт 10</u>-д заасан маягтын дагуу цахимд байршуулсан.
			4.3.2 Батлагдсан төсвийн бараа, ажил үйлчилгээг бэлтгэх “Худалдан авалтын төлөвлөгөө”-г гаргах ил тод мэдээлэх	Хөрөнгийн төсөв, НӨХГ-ын зөвшөөрөл	Худалдан авалтын журмыг дагаж шууд худалдан авах босго үнээс давсан хөрөнгийн зах зээлийн үнийн судалгааг явуулж “Өмч хамгаалах байнгын зөвлөл”, “Техникийн алба”-аар шийдвэрлүүлсэн. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг <u>хавсралт 8</u> -д заасан маягтын дагуу цахимаар мэдээлж, холбогдох гэрээнүүдийг Файл хэлбэрээр хавсаргав.
			4.3.3 Мэргэжлийн болон аудитын хөндлөнгийн хяналтын шалгалтад хамрагдаж өгсөн үнэлэлт, дүгнэлтийг ил тод мэдээлэх	Үнэлэлт дүгнэлт, зөрчлийн дүн	2014 оны санхүүгийн аудитын дүгнэлтийг дэлгэрэнгүй байдлаар /Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын нэгдсэн дүгнэлт/ байгууллагын сайтад байршуулсан.

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ

Ц.ПҮРЭВДАШ

НЭГТГЭСЭН:
ДЭД ЗАХИРАЛ

С.АРИУНБОЛД